**БАТЛАВ:**
БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА П.ОЮУНЦЭЦЭГ

9011285 0424020002 AMT100227

# БУЛГАН АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН ЭМНЭЛЭГ ТЕХНОЛОГИЙН ДААЛГАВАР

2024.06.20 № Булган сум

| № | Төлөвлөлтийн чиглэл | Эмнэлэг технологийн шаардлага |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл | Булган аймгийн Засаг даргын 2020-2024 оны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр<br>Монгол улсын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 2019.06.10, 06-07021/73<br>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын "Барилгын оношлогоо, газар хөдлөлт тэсвэршлийн паспортжуулалт"-ийн 2023 оны 12 сард "Бүүвэй цагаан барс" ХХК-д боловсруулсан дүгнэлт<br>Булган аймгийн Эрүүл мэндийн газраас 2024 оны 06 сарын 20 нд боловсруулсан Аймгийн нэгдсэн эмнэлгийн хэрэгцээний дүгнэлт |
| 2 | Эмнэлгийн төрөл | Аймгийн нэгдсэн эмнэлэг |
| 3 | Барилгын зориулалт, хүчин чадал | Аймгийн 160 ортой нэгдсэн эмнэлгийн барилга |
| 4 | Байршил, газрын мэдээлэл | Булган аймгийн 6-р багийн Л.Энэбишийн 1-р гудамжны 101 тоотод 31100 м$^2$ талбайг 2018 оны 09 сарын 05 нд аймгийн Засаг даргын А/524 тоот захирамжаар аймгийн нэгдсэн эмнэлэгт олгосон. |
| 5 | Хөрөнгө оруулалт | Улсын төсөв |
| 6 | Захиалагч | ЭМЯ, Булган аймгийн ЭМГ |
| 7 | Барилгын ажлын төрөл | Өргөтгөл шинэчлэлийн ажил |
| 8 | Ажлын зураг төсөв боловсруулах үе шат, хугацаа | Ажлын зураг боловсруулах ажил 2 үе шаттай<br>1-р шат Барилгад зохиогчийн зүгээс үзлэг хэмжилт, инженерийн судалгааны ажлыг хийж барилгын их засвар, өргөтгөлийн загвар зураг төслийг боловсруулах<br>2-р шат ажлын зураг төслийг боловсруулах<br>Ажлын зураг боловсруулах хугацааг гэрээгээр тогтооно. |
| 9 | Ажлын зураг төсөв боловсруулах байгууллагад тавигдах шаардлага | Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эмнэлгийн барилгын зураг төсөв боловсруулах туршлага бүхий аж ахуйн нэгж. |
| 10 | Барилгын үндсэн бүтээц | Үндсэн барилга даацын тоосгон ханатай Холбох барилга төмөр бетон араг бүтээцтэй. |
| 11 | Өргөтгөл шинэчлэлийн ажлын явцад гүйцэтгэх ажил | Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээний дүгнэлтэнд үндэслэн 100 ортой нэг маягийн нэгдсэн эмнэлгийн барилгыг одоо байгаа барилгын зарим хэсэгтэй холбох замаар гүйцэтгэх |
| 12 | Эмнэлгийн бүтцийг бүрдүүлэх тасаг, нэгжүүдийн нэр | Амбулатори болон больниц тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих нэгжүүдээс бүрдэнэ. Эмнэлгийн бүтцийг хавсралтаас үзнэ үү. |

| | | |
|---|---|---|
| 13 | Орон тоо зохион байгуулалтын бүтэц | MNS5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа стандартын дагуу орон тоог авлаа. |
| 14 | Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага | Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНбД 31-22-21 норм дүрмийн 4-р шаардлагыг хангасан байна. |
| 15 | Холбох ажлын зургийн тухай | 100 ортой нэгдсэн эмнэлгийн цогцолбор барилгын нэг маягийн ажлын зураг төслийг БХБЯ,ЭМЯ-ны захиалгаар "Зураг төсөл консалтинг" ХХК-д боловсруулсан. Энэ цогцолбор нь 5 блокоос бүрдэх бөгөөд<br>А блок Амбулаторийн барилга 24,0х32,0 хэмжээтэй зоорьгүй 3 давхар бөгөөд хүзүүвчээр В блоктой холбогдоно.<br>В блок Нөхөн сэргээх болон лабораторийн барилга 24х24м-ийн хэмжээтэй зоорьгүй 4 давхар бөгөөд А болон С блок руу хүзүүвчээр холбогдох<br>С блок Хэвтэн эмчлүүлэх тасгуудын барилга нь тэнхлэгээрээ 24х57 м хэмжээтэй зоорьтой 3 давхар бөгөөд А,В блоктой хүзүүвчээр холбогдоно.<br>Д блок Гал тогооны барилга 30х12,8м хэмжээтэй зоорьгүй 1 давхар<br>Ё блок Эмгэг анатомийн барилга 18х12 м-ийн хэмжээтэй зоорьгүй, өрөгт хийцтэй барилга юм.<br>Энэ барилгын блокуудаас их засвар хүчитгэл хийх барилгатай холбохдоо хуучин барилгын нөхцөл байдлыг харгалзан зохих блокуудыг авч холбоно. |
| 16 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өнөөгийн байдал | Булган аймгийн 160 ортой нэгдсэн эмнэлгийн барилгыг тэр үеийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн яамны Барилгын зургийн институтэд боловсруулсан 3196/71 шифртэй "160 ортой нэгдсэн больниц"-ийн нэг маягийн зураг төслийг 1982 оны 11 сарын 13-ны өдөр Булган хотын тухайн байршлын инженер геологийн нөхцөлд тохируулан холбож угсралтыг Булган аймгийн Барилга угсралтын трест гүйцэтгэн 1987 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.<br>Уг барилга нийтдээ 3 блокоос бүрдэх 3 давхар барилга бөгөөд<br>Барилгын өндөр 9,9м<br>А блок 12х96,25м<br>Б блок 14х32,4м<br>В блок 10,8х46,0м<br>4 заадастай /А блок 2 заадастай/<br>Хэсэгчилсэн зоорьтой<br>Лифтийн 2 хонгилтой.<br>Суурь-цутгамал төмөр бетон<br>Хана-тоосгон 640мм даацын<br>Хучилт-угсармал төмөр бетон<br>Дээвэр -хавтгай байсаныг шувуу нуруутай долгионт төмөр хучлагатай болгосон.<br>Цонх-2 давхар шилтэй хуванцар<br>Хаалга-гадна платамассан, дотор модон<br>Барилгын ерөнхий төлөв байдал дотоод эзлэхүүн төлөвлөлт нь эмнэлгийн барилгын төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангахгүй. Газар хөдлөлийн тэсвэршилт муу<br>Аймгийн нэгдсэн эмнэлгийн эзлэхүүн төлөвлөлтийг "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS |

| | | |
|---|---|---|
| | | 5095:2017 стандарт болон бусад холбогдох стандартууд болон "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНбД 31-22-21, Эмнэлгийн барилга БД31-115-12 нормуудтай нийцүүлэн шинээр төлөвлөх бөгөөд энэ төлөвлөлттэй уялдуулан барилгад хийгдэх засварын ажил болон өргөтгөлийн барилгын төлөвлөлттэй уялдуулан холбогдох зохицуулалтуудыг хийсэн байна. Ингэхдээ барилгын бат бэх тогтворжилтонд нөлөөлөх ямар нэгэн зүйлийг гаргаж болохгүй.<br>Одоо байгаа барилгын дотоод заслыг бүрэн буулгаж орчин үеийн шинэ материалаар эмнэлгийн барилгын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх<br>Заслын ажилд "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНбД 31-22-21 норм дүрмийн 5.4-д заагдсан шаардлагуудыг харгалзан хэрэгжүүлэх<br>Тухайн өрөө тасалгаануудын шалны хийцлэл болон дотоод өнгөлгөөний өнгийг тухайн өрөө тасалгааны зориулалтын шаардлагад нийцүүлэх<br>Барилгын цонх хаалгыг бүрэн буулгаж солих ба коридорийн өргөн стандартын шаардлага хангахгүй байгаа нөхцөлд хаалгыг гүйдэг болгож өөрчлөх<br>Өрөөнүүдийг босгогүй болгох<br>Өмнө хийгдсэн засварын ажлын явцад агаарын урсгалын горим алдагдсан байгааг шаардлагад нийцүүлэх<br>Одоо байгаа нэгдсэн эмнэлгийн барилга нь 2023 оны 12 дугаар сард "Бүүвэй цагаан барс" компанид боловсруулсан "Барилгын оношлогоо, газар хөдлөлт тэсвэршилтийн паспортжуулалтын дүгнэлт"-ээр газар хөдлөлийн тэсвэршлийн шаардлагыг хангахгүй байгаа тул<br>-барилгын дөр хануудыг төмөрбетон эсвэл гангаар цамц өмсгөн хүчитгэж БД31-106-03-ийн зөвлөмжийн дагуу хүчитгэх шаардлагатай.<br>-арматур нь ил гарч зэвэрсэн зоорийн давхрын цутгамал, хучилтын угсармал хавтангуудыг орчин үед хэрэглэж байгаа цутгалтын дараах нэмэлт хүчитгэлийн нэмэлт арматурчлал, ан цав үүссэн бетоныг хүчитгэх нэмэлттэй эпиксид цавуу ашиглах зэрэг хүчитгэлийн арга хэмжээ авах<br>-барилгын газар хөдлөлийн тэсвэршлийг дээшлүүлэх, ханын тогтворыг хангахын тулд "БД22-105-18 Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлийн тэсвэршлийг үнэлэх болон хүчитгэх аргачлал"-ын дагуу хүчитгэл хийх<br>-Хулдаасан болон керамик хавтанцар шалуудыг бүхэлд нь ховхолж, хөгц мөөгөнцөрийг арилгаж шинээр цементэн тэгшилгээг хийж шалыг бүхэлд нь шинэчлэх<br>-Барилгын дулаан алдагдлыг багасгаж хөрснөөс дулаан алдаж байгааг зогсоох<br>-Барилгын усыг барилгад халгүй зайлуулах арга хэмжээ авч хаяавчийг шинэчлэх гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх<br>Одоо байгаа барилгын дээврийг бүрэн буулгаж аянга хамгаалалтын болон ус зайлуулах системийг шинээр төлөвлөх.<br>Барилгын гадна өнгөлгөөг дулаалгатай металл өнгөлгөөгөөр гүйцэтгэхээр төлөвлөх.<br>Одоо байгаа барилгын өөрчлөлттэй уялдуулан нийтэд |

| | | |
|---|---|---|
| | | нь хүчитгэх зарим блокийг буулгах зэрэг арга хэмжээг авах талаар зөвлөх инженерүүдийн багийг ажиллуулан тодорхой шийдэл гаргах шаардлагатай. |
| 17 | Чиглэл бүрийн хэвтэн эмчлүүлэх тасгийн орны тоо, тэдгээрийн харьцаа | Хэвтэн эмчлүүлэх тасгуудын тоо, хэмжээ талбайн үзүүлэлтийг уг даалгаврын нэгдүгээр хавсралтанд заасан болно. |
| 18 | Амбулаторийн хүчин чадал, үзлэгийн кабинетуудын бүрэлдэхүүн, тоо | Амбулаторийн кабинетийн тоо, хэмжээ талбайн үзүүлэлтийг уг даалгаврын нэгдүгээр хавсралтанд заасан болно. |
| 19 | Эмнэлгийн технологийн онцлог, хэсэг тасгуудын хоорондын уялдаа холбоо | Хоорондоо уялдаа бүхий оношлогоо, эмчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тул тэдгээрийн өвчтнүүдийн аль аль нь ашиглаж болохуйцаар барилгын эзлэхүүн төлөвлөлтийг гүйцэтгэнэ. |
| 20 | Эмнэлгийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт | "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5095:2017 стандартын "В" хавсралтын дагуу |
| 21 | Хүлээн авах тасгийн үзлэгийн өрөө, хүлээн авах үзлэгийн бокс ба тусгаарлах оношлогооны өрөөний харьцаа | Хүлээн авах хэсгийн орны тоог дотрын эмчилгээний орны 2%, яаралтай мэс заслын орны 4%-тай тэнцүү тоогоор төлөвлөнө. |
| 22 | Эмнэлгээс гаргах өрөө төлөвлөх эсэх | Эмнэлгээс гаргах өрөө төлөвлөх |
| 23 | Эдэлбэр газарт буюу барилгын дээвэр дээр нисдэг тэрэг буух талбай төлөвлөх эсэх | Нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газар болох голын эрэг болон авто замын хооронд нисдэг тэрэгний буух талбай төлөвлөх |
| 24 | Тусгай хагалгааны өрөө төлөвлөх бол тэдгээрийн чиглэл ба тоо | Хагалгааны өрөөг гэмтлийн болон бусад хагалгааны гэж ялган төлөвлөх |
| 25 | Мэс заслын өрөө тасалгааг зохион байгуулах зарчим | Хагалгааны өрөөнүүдийг танхмийн голд тусгай битүү тойрсон коридорийн голд хамгаалагдсан тасалгаа үүсгэн түүний дотор хагалгааны өрөөг байгуулах замаар вакуум байдлаар 3 бүс үүсгэн төлөвлөх |
| 26 | Яаралтай ариутгал төлөвлөх шаардлага | Төлөвлөнө. |
| 27 | Зүрх судасны, мэдрэлийн, түлэнхийн, хордлогын тусгай сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг төлөвлөх шаардлага | Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний нэгдсэн тасгийг залны системээр төлөвлөх. Орны тоог 6 байна гэж төлөвлөх.<br>Зүрх судасны эрчимт эмчилгээний өрөөг тухайн зорилгоор палатанд төлөвлөж болно. |
| 28 | Даралтат хүчилтөрөгчийн тасаг байгуулах хэрэгцээ, хүчин чадал | Тасгийн бүрдэлд эмчилгээний өрөө тасалгаа, өвчтөний хүлээлгийн өрөө, тасгийн нийтлэг өрөөнүүд, эмнэлгийн болон техникийн ажилтнуудын өрөө, туслах өрөө тасалгаа багтана. Амбулаторийн өвчтөнүүдэд хувцас солих кабин, амралтын өрөө төлөвлөнө.<br>Энэ тасгийг 2-оос цөөнгүй, 8-аас олонгүй нэг хүний даралтат камертайгаар байгуулна. Энэ тасгийн талбай 40м$^2$-аас багагүй байна. Шаардлагагүй |
| 29 | Сэтгэц мэдрэлийн тасагт ажиглалтын палат төлөвлөх эсэх зэрэг СМТ-ын төлөвлөлтийн онцлог, | Сэтгэц мэдрэлийн тасагт ажиглалтын палат төлөвлөх, эмч сувилагчдын үйлчлэх замыг аль болох бага байхаар, нөгөө талаас тасгийн рекреацийн хэмжээ, хэлбэр нь өвчтөнүүд удаан хугацаагаар алхах хэрэгцээг хангахуйц байх, |

| | | |
|---|---|---|
| | шаардлагууд | Сэтгэц мэдрэлийн тасгийн палатны болон бусад өрөөний цонхыг хагардаггүй шилээр шиллэх ба онгойх хэсгийн доод түвшин 1.6 м-ээс багагүй, цонхны тавцан 10 см-ээс ихгүй өргөнтэй байна |
| 30 | Ус шавар эмчилгээний тасгийн хүчин чадал | Эмнэлгийн зориулалтын барилга төлөвлөх БНбД 31-22-21 нормын 5.10.1.16-аас 5.10.1.32-ийн заалтад уг тасгийн өрөө, тоног төхөөрөмжийг үзүүлсэн болно. Харин хүчин чадлыг хавсралт нэгд заасан болно. |
| 31 | Алсын зайн эмчилгээ оношлогооны төвийн хүчин чадал, тавигдах тоног төхөөрөмжийн төрөл тоо | Алсын зайн зөвлөгөө оношлогооны төвийн өрөө тасалгааны бүрдэлд видео-хурал хийх, алсын зайн семинар, лекц явуулах танхим, алсын зайн зөвлөгөөг, холбооны тоног төхөөрөмж, шууд нэвтрүүлгээр болон бичлэгээр дамжуулан өгөх өрөө сервер ба өгөгдлийн бааз байрлуулах өрөө, техникийн ажилтны ажлын өрөө багтана |
| 32 | Онцгой нөхцөл | Одоо байгаа эмнэлгийн барилгын буурийн газар хөдлөлийн баллыг нарийвчлан тодруулах<br>Нэгдсэн эмнэлгийн барилгыг өөрчлөн төлөвлөх, шинээр барилгыг холбохдоо хуучин барилгыг хүчитгэх, тасгуудын хоорондын уялдаа холбоог сайтар анхаарах<br>Одоо байгаа барилгын зарим хэсгийг буулгах бололцоо байгааг нарийвчлан тодруулах<br>Түсдаа зориулалтын барилга бүхий 50 ортой төрөх эмнэлэг, 30 ортой халдварт сүрьяагийн эмнэлгийн үйл ажиллагааны уялдааг шинээр төлөвлөж байгаа нэгдсэн эмнэлгийн барилгын уялдааг хангах |
| 33 | Инженерийн шугам сүлжээ, түүний эх үүсвэрт тавигдах шаардлага | Дотор инженерийн шугам сүлжээний хангамжийг зайлшгүй байх байршлуудад эдийн засгийн хувьд үр ашигтай аюулгүй байдлын шаардлагыг хангаж төлөвлөх<br>Инженерийн шугам сүлжээнүүдийн хангамжийг нөөц эх үүсвэртэйгээр төлөвлөх |
| 34 | Галын аюулгүй байдлын шаардлага | "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД-21-01-02, "барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21-02-02,<br>"Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" БНбД 21-04-ийн шаардлагыг хангасан байна.<br>"Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" БнбД 31-22-21 нормын 7-р зүйлийг хангасан байна. |
| 35 | Зөвшилцөх байгууллагууд | Нэгдсэн эмнэлгийн удирдлагатай зөвшилцөн ГХБХБГ, ОБГ, ЭМГ-аар хянуулах шаардлагатай. |

Анхааруулах нь:

1.Нэгдсэн эмнэлгийн барилгын төлөвлөлтийг гүйцэтгэхдээ зохиогчийн зүгээс тус эмнэлгийн барилгад биеэр хэмжилт хийж, нөхцөл байдлыг тодруулсан байна.

2.Эмнэлгийн барилгад тасаг палатуудыг төлөвлөхдөө тэдгээрийн хүчин чадал, байршил, агаарын урсгал, болон эмнэлгийн хийн хангамжийн шаардлагыг сайтар харгалзаж барилгын бат бэхэд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцлийг хангасан байх шаардлагатай.

3.Барилгын орон зайн төлөвлөлтөд нэгдсэн эмнэлгийн холбогдох албан тушаалтнуудыг заавал оролцуулж зөвшилцөх шаардлагатай.

4.Даалгаварт заагдсан газар хөдлөлийн тооцоот балл, галын аюулгүйн категори зэргийг өөрчилж болохгүй. Хэрвээ зайлшгүй нөхцөл байдлаас хамааран өөрчлөх бол аймгийн ГХБХБГ-тай заавал зөвшилцөх шаардлагатай.

**Зөвшөөрсөн:**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ ...../М.Мягмар/
эрхэлсэн орлогч дарга

Аймгийн ерөнхий архитектор ...../М.Цэрэнчимэд/

**Хянасан:**

Булган аймгийн Газрын харилцаа, ...../Б.Ганзориг/
барилга хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн
дарга

**Боловсруулсан:**

Барилга хот байгуулалтын хэлтсийн ...../Н.Гүржав/
мэргэжилтэн